



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/05/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Архангай аймаг

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Аудитор Л.Соёлмөнх

Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
БОАЖГ	Баягаль орчин, аялал жуулчлалын газар



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.25 № 101

танай _____ -ны № _____ -т

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА Б.ЕШИЙ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас зориулалт бусаар 14.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 43-р тогтоолын хавсралтаар баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам", 2021 оны төсвийн хэмнэлтийн 43-р тогтоолын 1.5 дахь заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	62,448,692.92	56,429,834.09
35	БАРАА МАТЕРИАЛ	62,448,692.92	56,429,834.09
35100	Түүхий эд материал	48,882,466.92	43,949,446.09
35110	Тусгай зориулалттай материал	48,882,466.92	43,949,446.09
35400	Хангамжийн материал	13,566,226.00	12,480,388.00
35420	Аж ахуйн материал	3,266,150.00	3,616,150.00
35440	Түлш, шатах тослох материал	695,000.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	9,605,076.00	8,864,238.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	163,606,176.26	217,593,603.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	163,606,176.26	217,593,603.64
39200	Биет хөрөнгө	151,846,176.26	206,073,603.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	21,122,629.40	21,122,629.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	-6,871,122.72	-10,872,913.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	195,579,505.00	127,193,615.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-104,503,505.12	-72,596,948.66
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	106,680,067.00	106,343,675.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-91,614,784.63	-83,902,335.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,236,801.85	25,612,110.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,632,804.47	-25,275,833.99
39214	Бусад үндсэн хөрөнгө	82,034,326.00	167,960,483.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-51,195,936.05	-49,521,877.80
39217	Ном	11,000.00	11,000.00
39300	Биет бус хөрөнгө	11,760,000.00	11,520,000.00
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-540,000.00	-780,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,800,000.00	10,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	226,054,869.18	274,023,437.73
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,295,469.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,295,469.00	0.00
41300	Өглөг	1,295,469.00	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,295,469.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	224,759,400.18	274,023,437.73
51	Засгийн газрын хувь оролцоо	224,759,400.18	274,023,437.73
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	210,736,397.50	210,736,397.50
51200	Хуримтлагдсан үр дүн	7,422,289.40	56,686,326.95
51210	Өмнөх үеийн үр дүн	35,683,291.26	7,422,289.40
51220	Тайлант үеийн үр дүн	-28,261,001.86	49,264,037.55
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,600,713.28	6,600,713.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	226,054,869.18	274,023,437.73

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	955,746,031.00	1,003,292,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,132,636.00	49,815,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	23,132,636.00	49,815,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,132,636.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	269,000.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	22,863,636.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	49,815,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	932,613,395.00	953,476,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,566,595.00	22,392,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,566,595.00	22,392,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	894,046,800.00	931,084,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	894,046,800.00	931,084,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	984,007,032.86	942,756,196.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	984,007,032.86	942,756,196.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	952,120,263.69	732,531,833.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	477,416,111.83	444,525,430.00
210101	Үндсэн цалин	381,922,280.83	320,944,211.00
210102	Нэмэгдэл	78,781,031.00	106,165,630.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,712,800.00	17,415,589.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,796,820.13	57,697,795.09
210201	Тэтгэврийн даатгал	40,826,858.81	39,916,777.89
210202	Тэтгэмжийн даатгал	4,745,398.37	4,445,254.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,795,590.04	3,556,203.92
210204	Ажилгүйдлийн даатгал	948,174.39	889,050.38
210205	Эрүүл мэндийн даатгал	9,480,798.52	8,890,508.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,821,821.00	10,505,760.00
210301	Гэрэл, цахилгаан	610,812.12	135,365.00
210302	Түлш, халаалт	8,873,088.00	8,873,088.00
210303	Цэвэр, бохир ус	337,920.88	1,497,307.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,291,193.87	13,867,188.83
210401	Бичиг хэрэг	5,432,050.00	1,536,280.00
210402	Тээвэр, шатахуун	20,242,114.13	4,885,560.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,463,779.74	1,480,390.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	153,250.00	291,100.00
210408	Бараа материал акалсны зардал	0.00	5,673,858.83
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,574,380.00	501,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,469,000.00	330,000.00
210604	Урсгал засвар	105,380.00	171,500.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	2,088,000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	2,088,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	285,685,768.00	131,845,006.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	284,440,180.00	130,830,350.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	330,000.00	280,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	175,588.00	142,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	33,000.00
210807	Газрын төлбөр	40,000.00	28,956.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	200,000.00	30,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,534,168.86	71,501,153.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,390,330.00	22,392,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,143,838.86	49,108,753.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,886,769.17	210,224,362.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,288,790.00	35,213,179.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,289,800.00	31,098,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,998,990.00	2,499,379.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,597,979.17	175,011,183.91
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,597,979.17	175,011,183.91
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,000,000.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-28,261,001.86	60,536,203.51
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	11,272,165.96
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	11,272,165.96
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-28,261,001.86	49,264,037.55

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	209,936,397.50	6,600,713.28	35,683,291.26	252,220,402.04
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	209,936,397.50	6,600,713.28	35,683,291.26	252,220,402.04
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	800,000.00	0.00	0.00	800,000.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-28,261,001.86	-28,261,001.86
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	210,736,397.50	6,600,713.28	7,422,289.40	224,759,400.18
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	210,736,397.50	6,600,713.28	7,422,289.40	224,759,400.18
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	210,736,397.50	6,600,713.28	7,422,289.40	224,759,400.18
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	49,264,037.55	49,264,037.55
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	210,736,397.50	6,600,713.28	56,686,326.95	274,023,437.73

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	932,882,395.00	953,476,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	269,000.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	269,000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	269,000.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	269,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	932,613,395.00	953,476,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,566,595.00	22,392,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,566,595.00	22,392,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	894,046,800.00	931,084,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	894,046,800.00	931,084,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	928,672,395.00	888,924,053.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	928,672,395.00	888,924,053.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	896,785,625.83	678,699,690.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	476,120,642.83	445,820,899.00
210101	Үндсэн цалин	380,626,811.83	322,239,680.00
210102	Нэмэгдэл	78,781,031.00	106,165,630.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,712,800.00	17,415,589.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,796,820.13	57,697,795.09
210201	Тэтгэврийн даатгал	40,826,858.81	39,916,777.89
210202	Тэтгэмжийн даатгал	4,745,398.37	4,445,254.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,795,590.04	3,556,203.92
210204	Ажилгүйдлийн даатгал	948,174.39	889,050.38
210205	Эрүүл мэндийн даатгал	9,480,798.52	8,890,508.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,821,821.00	10,505,760.00
210301	Гэрэл, цахилгаан	610,812.12	135,365.00
210302	Түлш, халаалт	8,873,088.00	8,873,088.00
210303	Цэвэр, бохир ус	337,920.88	1,497,307.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,883,029.74	8,193,330.00
210401	Бичиг хэрэг	999,400.00	1,536,280.00
210402	Тээвэр, шатахуун	7,259,600.00	4,885,560.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,470,779.74	1,480,390.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	153,250.00	291,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,574,380.00	851,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,469,000.00	680,000.00
210604	Урсгал засвар	105,380.00	171,500.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	2,088,000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	2,088,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	331,315,213.00	131,150,006.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	330,069,625.00	130,135,350.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	330,000.00	280,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	175,588.00	142,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	33,000.00
210807	Газрын төлбөр	40,000.00	28,956.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	200,000.00	30,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,273,719.13	22,392,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,273,719.13	22,392,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,886,769.17	210,224,362.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,288,790.00	35,213,179.00

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	1,615,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,289,800.00	31,098,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,998,990.00	2,499,379.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,597,979.17	175,011,183.91
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,597,979.17	175,011,183.91
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,000,000.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,210,000.00	64,552,847.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,210,000.00	64,552,847.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,210,000.00	64,552,847.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,210,000.00	64,552,847.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,210,000.00	64,552,847.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-4,210,000.00	-64,552,847.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	931,084,500.00	756,073,316.09	175,011,183.91	81.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	931,084,500.00	756,073,316.09	175,011,183.91	81.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	895,870,700.00	720,860,137.09	175,010,562.91	80.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	471,106,000.00	445,820,899.00	25,285,101.00	94.63
210101	Үндсэн цалин	365,042,200.00	322,239,680.00	42,802,520.00	88.27
210102	Нэмэгдэл	89,547,300.00	106,165,630.00	-16,618,330.00	118.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,516,500.00	17,415,589.00	-899,089.00	105.44
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,151,500.00	57,697,795.09	2,453,704.91	95.92
210201	Тэтгэврийн даатгал	42,507,300.00	39,916,777.89	2,590,522.11	93.91
210202	Тэтгэмжийн даатгал	4,411,100.00	4,445,254.30	-34,154.30	100.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,528,800.00	3,556,203.92	-27,403.92	100.78
210204	Ажилгүйдлийн даатгал	882,200.00	889,050.38	-6,850.38	100.78
210205	Эрүүл мэндийн даатгал	8,822,100.00	8,890,508.60	-68,408.60	100.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,526,500.00	10,505,760.00	20,740.00	99.80
210301	Гэрэл, цахилгаан	659,000.00	135,365.00	523,635.00	20.54
210302	Түлш, халаалт	9,282,600.00	8,873,088.00	409,512.00	95.59
210303	Цэвэр, бохир ус	584,900.00	1,497,307.00	-912,407.00	255.99
2104	Хангамж, бараа материалын зардал	8,194,200.00	8,193,330.00	870.00	99.99

Баягаль орчин аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	2,158,200.00	1,536,280.00	621,920.00	71.18
210402	Тээвэр, шатахуун	4,839,800.00	4,885,560.00	-45,760.00	100.95
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,068,500.00	1,480,390.00	-411,890.00	138.55
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	127,700.00	291,100.00	-163,400.00	227.96
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,116,900.00	3,065,000.00	51,900.00	98.33
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,945,200.00	2,893,500.00	51,700.00	98.24
210604	Урсгал засвар	171,700.00	171,500.00	200.00	99.88
2107	Томилолт, зочны зардал	2,136,700.00	2,088,000.00	48,700.00	97.72
210702	Дотоод албан томилолт	2,136,700.00	2,088,000.00	48,700.00	97.72
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	340,638,900.00	193,489,353.00	147,149,547.00	56.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	339,458,300.00	192,474,697.00	146,983,603.00	56.70
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	280,500.00	280,000.00	500.00	99.82
210804	Тээврийн хэрэгслийн татвар	146,700.00	142,700.00	4,000.00	97.27
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	96,700.00	33,000.00	63,700.00	34.13
210807	Газрын төлбөр	50,000.00	28,956.00	21,044.00	57.91
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	106,700.00	30,000.00	76,700.00	28.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,213,800.00	35,213,179.00	621.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,213,800.00	35,213,179.00	621.00	100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,615,000.00	1,615,000.00	0.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,098,800.00	31,098,800.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	2,499,379.00	621.00	99.98
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	931,084,500.00	756,073,316.09	175,011,183.91	81.20
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	931,084,500.00	756,073,316.09	175,011,183.91	81.20
320001	Орон нутгийн төсвөөс	931,084,500.00	756,073,316.09	175,011,183.91	81.20
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	49	49	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	45	45	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	3	3	0.00	100.00

2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,392,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,392,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,392,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,392,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,392,400.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,392,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,392,400.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,392,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,000,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Соёлмөнх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь нутаг дэвсгэртээ иргэдийн хуулиар баталгаажсан эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгаль орчин, ногоон хөгжлийн суурь үзэл санааг хэрэгжүүлэн байгалийн нөөц баялгийг тогтвортой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх зорилготой аймгийн ТЕЗ-ийн харьяа тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага байна.

Тус байгууллага нь тайлант онд дараах зорилтуудыг тавин ажилласан байна. Үүнд:

- ✓ Байгаль орчны удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, бодлогийн хэрэгжилтийг ханган ажиллах.
- ✓ Байгаль орчны менежмент, иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх.
- ✓ Байгаль орчныг хамгаалах, нөөц баялгийн ашиглалт ба нөхөн сэргээлтийн ажлыг стандартын түвшинд хүргэх.
- ✓ Байгаль орчны доройтол, орчны бохирдолттой тэмцэх.
- ✓ Байгаль орчны багц хуулийн хэрэгжилт хяналт, шалгалтыг зохион байгуулах.
- ✓ Байгаль орчны судалгаа, шинжилгээ, мэдээллийн санг бүрдүүлэх.
- ✓ Байгаль орчны мэдээлэл, сургалт сурталчилгааг зохион байгуулах.
- ✓ Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх.
- ✓ Байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн дотоод ажил, үйлчилгээг хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-иар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн.
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баягаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/82 дугаар тушаалаар дотоод хяналт, шинжилгээ үнэлгээний байнгын комиссыг томилсон бөгөөд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд аудитаас дотоод хяналт, шинжилгээ үнэлгээний байнгын комиссын үйл ажиллагааг эрчимжүүлэх, байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах **зөвлөмжийг** хүргүүлээ.

Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн байгууллагын дотоод хяналт нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэсэн заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурель сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр бэлтгэж, тайлбар танилцуулгын хамт ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг нийт зардал 984.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 9.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 7.3 сая төгрөгөөр тогтоосон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 942.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 9.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 7.0 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 21.2 хувиар өссөн материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	хувь
Бараа материал	62.45	56.43	(6.0)	-9.6
Үндсэн хөрөнгө	163.6	217.59	54.0	33.0
Нийт хөрөнгө	226.05	274.02	48.0	21.2
Өр төлбөр	1.29	0	-	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	224.76	274.02	49.3	21.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	226.05	274.02	48.0	21.2

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материал эхний үлдэгдлээс 9.6 хувиар буурсан байна.

Бараа материалын данс нь 62.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 18.9 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж, 24.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан данснаас хасч, оны эцэст 56.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 33.0 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 446.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд “Аз таван булаг” ХХК-аас болон “Гэр электроник” ХХК-аас 14.8 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг, “Тайгер Дизайн” ХХК-аас 49.7 сая төгрөгийн хогийн сав худалдан авсан, аймгийн Засаг даргын Тамгын газраас 49.8 сая төгрөгийн Улсын чанартай авто замын дагуух ногоон байгууламжийн хамгаалалтын

хашааг үнэ төлбөргүй шилжүүлэн авч данс бүртгэлд тусгаж, нийт 114.3 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, 100.7 сая төгрөгийн хөрөнгийг актлаж данснаас хасч, тайлант хугацаанд байгуулсан 242.9 сая төгрөгийн элэгдлээр буурч, 217.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн 49.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 49.3 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	23.13	49.82	26.69
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	894.04	931.08	37.04
Нэмэлт санхүүжилт	38.57	22.39	-16.18
Үйл ажиллагааны орлого	955.74	1,003.29	47.55
Цалин, шимтгэлийн зардал	537.21	502.22	-34.99
Бараа ажил үйлчилгээний зардал	41.7	26.97	-14.73
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	285.68	131.85	-153.83
Бараа үйлчилгээний бусад зардал	87.53	71.5	-16.03
Урсгал шилжүүлэг	31.88	210.22	178.34
Хөрөнгийн зардал			0
Үйл ажиллагааны зардал	984	942.76	-41.24
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-28.26	60.53	88.79

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 47.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, нэг удаагийн тэтгэмж өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 1053.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 122.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зардлыг 931.0 сая төгрөгөөр хянаж баталсан бол тодотголоор батлагдсан төсөвт өөрчлөлт ороогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 931.0 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны зардалд 591.6 сая, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд 339.4 сая, нийт 931.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, 756.0 сая төгрөгийг зарцуулан 175.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн тайлагнагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсөв захирагчаас 22.3 сая төгрөгийн орлого төвлөрснийг зарцуулах эрхийн хүсэлт нээлгэн бараа үйлчилгээний бусад зардалд буюу мод бутны суулгац худалдан авахад зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын удирдлага тайланд онд хоёр удаа солигдсон бөгөөд аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Б/80 дугаар захирамжаар БОАЖГ-ын даргаар Г.Алтан-Очирыг томилж, 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Б/55 дугаар захирамжаар чөлөөлж, Б.Ешийг 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Б/59 захирамжаар БОАЖГ-ын даргаар томилсон байна.

Аймгийн засаг даргын 2021 оны 02 сарын 02-ны өдрийн “Ойн нэгж, сум дундын ойн ангиудыг байгуулж бүтэц, орон тоог батлах тухай” А/63 дугаар захирамжаар Байгаль орчин аялал жуулчлалын газрын дэргэдэх Ойн нэгж, Цэнхэр, Ихтамир, Эрдэнэмандал сумдад ойн ангиудыг шинээр байгуулсан байна. Бүтэц орон тооны хувьд Ойн нэгж нь дарга, мэргэжилтэн гэсэн 2 орон тоотой, сумдын ойн ангиуд дарга, ойн хортон, түймэр, ойн ашиглалт, мод бэлтгэл, талбай тусгаарлалт, хариуцсан инженер буюу ахлах мэргэжилтэн, мод үржүүлэг, ойн нөхөн сэргээлт хариуцсан мэргэжилтэн, ойн техникч, жолооч гэсэн 5 орон тоотой байхаар батлагдсан байна. Тус анги нэгжүүд сар улирлаар тухай бүр ажлаа байгаль орчин аялал жуулчлалын газрын даргад танилцуулан тайлагнаж ажиллаж байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 339.4 сая төгрөгийг 17 арга хэмжээнд зарцуулахаар баталсан бөгөөд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь, хэмжээг мөрдөөгүй байна.

Хүснэгт 3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу 2021 онуудын хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний төлөвлөлтүүд

/сая.төгрөг/

Орлогын нэр төрөл	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан зарцуулах хувь хэмжээний доод хязгаар	2021 он				
		Төлвөрүүлсэн орлого	Хуулийн 18.1-д заасан хувь хэмжээгээр тооцсон зарцуулбал зохих хөрөнгө	ИТХТ-ийн Баталсан зардлын дүн	Зарцуулалт /-илүү, +дугуу/	Харьцуулсан хувь
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	15%	2,459.16	368.87		368.87	-
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	50%	8.74	4.37	14.00	(9.63)	31.21
Газрын нөөцийн төлбөр	15%		-		-	-
Ойн нөөц ашигласны төлбөр	85%	300.89	255.76	114.50	141.26	223.37
Ус рашаан ашигласны төлбөр	35%	58.88	20.61	131.05	(110.44)	15.73
Бүгд		2,827.67	649.61	259.55	390.06	250.28
Бусад арга хэмжээнд зарцуулах хөрөнгө				79.90		23.50
Нийт дүн		2,827.67	649.61	339.45	390.06	273.78

Мөн Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-д заасны дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар батлагдсан 17 арга хэмжээний 339.4 сая төгрөгөөс ойн хөнөөлт шавьж, цэвэрлэгээ, менежменттэй холбоотой 7 арга хэмжээнд 114.5 сая төгрөгийг, ан агнууртай холбоотой 2 арга хэмжээнд 14.0 сая төгрөгийг, ус рашаантай холбоотой 3 арга хэмжээнд 131.0 сая төгрөгийг журмын дагуу зарцуулахаар төлөвлөсөн бол журамд хамаарахгүй 5 арга хэмжээнд 79.9 сая төгрөг буюу 23.5 хувь нь үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулагдахаар тус тус төлөвлөгдсөн байна.

Тайлант онд гүйцэтгэлээр Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 339.4 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, 192.4 сая төгрөгийг зарцуулан 146.9 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Тухайн онд хэрэгжүүлэхээр баталсан 17 арга хэмжээний хэрэгжилтийг авч үзэхэд "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-д заасан 12 арга хэмжээнд 114.4 сая төгрөгийг, уг журамд заагаагүй 5 арга хэмжээнд 78.0 сая төгрөг буюу тус зардлын 40.5 хувь нь үр ашиггүй, зориулалт бус зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 18 үндсэн зорилтын хүрээнд 56 арга хэмжээг

хэрэгжүүлэхээр төлөвлөж дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 86.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 931.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 81.2 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэлэхэд Үүнд:

- ❖ Тус байгууллага нь тайлант онд 49.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч тайланд бүрэн тусгасан байна.
- ❖ Тайлант жилд шинээр аймгийн Засаг даргын 2021 оны 02 сарын 02 –ны өдрийн А/63 дугаар захирамжаар Байгаль орчин аялал жуулчлалын газрын дэрэгдэх Ойн нэгжийг шинээр байгуулж, 2 албан тушаал/ ойн нэгийн дарга, мэргэжилтэн/-ыг нэмэгдүүлэн 43.3 сая төгрөгийн цалинг олгосон байна.
- ❖ Тайлант хугацаанд БОАЖГ-ын харуул Н.Содномдамба, байгаль хамгаалагч Л.Баярсайхан нар 2021 оны 6 болон 9 сард өндөр насны тэтгэвэр тогтоолгож ажлаас чөлөөлөгдсөн байна. Тус албан тушаалын орон тоонуудад нөхөн томилгоо хийж 3.6 сая төгрөгийн цалин олгосон байна.
- ❖ Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 4-н тээврийн хэрэгсэл байдаг бөгөөд Аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 56 дугаар тогтоолоор БОАЖГ-ын Toyota Альфард маркийн 66-03АРХ, Hyundai Portor маркийн 25-64АРА, УАЗ 390942-018 пургон маркийн 82-20АРА улсын дугаартай 3-н тээврийн хэрэгслүүдийг акталж худалдсан байна.
- ❖ Тайлант онд 1 тээврийн хэрэгсэлд 11.6 сая төгрөгийн шатахуун, 0.3 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл зарцуулсан, орон тооны 1 жолоочтой, жолоочийн цалинд 11.7 сая төгрөгийг олгожээ.
- ❖ Байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх зардлаас “Үлэмж Медиа” ХХК болон “Ар Би Эм Ти” ХХК-тай тус бүр 2.0 сая төгрөгийн гэрээг байгуулан ажилласан байна.

Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хууль, Монгол улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43-р тогтоолын хэрэгжилтийг шалгалаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулахаас 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг мэдээллээгүй бөгөөд өмнөх аудитаар зөвлөмж өгөгдсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-6.10-д заасан “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ ...”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг мэдээллэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж зөрчлийг арилгуулах **албан шаардлага** хүргүүллээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд батлагдсан төсвөөс 43 хувийн буюу 175.0 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн тувшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй, Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт нь холбогдох шалгуурт нийцэж байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд тээвэр шатахууны зарцуулагдаагүй үлдэгдэл 0.6 сая төгрөгийг төвлөрүүлэлгүй нөөц бэлтгэсэн зөрчилд төлбөрийн акт тогтоосон, шилэн данстай холбоотой 1 зөвлөмж өгч биелэлтийг бүрэн хангуулсан.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 93.3 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 0.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 92.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, дотоод хяналттай холбоотой 1 зөвлөмжийг өглөө.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 14.7 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 9.4 сая төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Төлбөрийн акт тогтоох

4.1.1. Цалингийн зардлаас сахилгын шийтгэлтэй 2 ажилтанд 0.5 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийг хэмнэлтийн Засгийн газрын 43 дугаар тогтоол болон Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцээгүй байна.

4.2 Албан шаардлага

4.2.1. Төсөвт зорицуулалт хийлгүйгээр 14.8 сая төгрөгийг зориулалт бус зарцуулан хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.5.5-д "Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах", "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 2021 оны 43-р тогтоолын 1.4-д "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.

4.2.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөхдөө арга хэмжээний хэрэгцээ шаардлага болон Монгол улсын Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах" журмын дагуу зарцуулахаар төсвийн төлөвлөлтийг хийгээгүйгээс 5 арга хэмжээний 78.0 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.5.5-д "Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах", Монгол улсын Засгийн газрын 2014 оны 43-р тогтоолын хавсралтаар баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт

Тайлант жилийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д заасны дагуу батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, дотоод хяналт, шинжилгээ үнэлгээний байнгын комиссын үйл ажиллагааг эрчимжүүлэх, байгууллагын дотоод хяналтыг сайжруулж ажиллах **зөвлөмжийг** өгч байна.

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	БОАЖГ	4	93.3	0	0	1	0.5	2	92.8	1	0
	дүн	4	93.3	0	0	1	0.5	2	92.8	1	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	БОАЖГ	1	0	0	0	0	0	1	0	0	0
	дүн	1	0	0	0	0	0	1	0	0	0
	Нийт дүн	5	93.3	0	0	1	0.5	3	92.8	1	0